



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/173

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Тогтвортой хөгжлийн боловсрол” дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах “Эко сургууль, цэцэрлэг хөтөлбөр” арга зүйн сургалтын зардалд 3,536,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.


2. Зардалд зарцуулагдах 3,536,000 төгрөг (гурван сая таван зуун гучин зургаан мянга)-ийг 2022 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.2 дахь “Боловсролын салбарын дэд хөтөлбөрүүд (Тогтвортой хөгжлийн боловсрол)” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дүгээр сарын 05-ны өдрийн
А/173 дугаар захирамжийн
хавсралт

“ЭКО СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ ХӨТӨЛБӨР” АРГА ЗҮЙН
СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын төрөл	Тоо хэмээ	Нэг бүрийн үнэ	Нийт зардал
1	Сургалтын төлбөр	40	80000	3200000
2	Завсарлагааны цайны зардал	4*42	2000	336000
Дүн				3536000

-oOo-